



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б. БИЛЭГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-05 № 06/37 7/АГ-СМТ/2013/26/СГА-ТТЗ

Зөрчлийг арилгуулах тухай

Цагдаагийн ерөнхий газрын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараахь зөрчил илэрлээ.

Цагдаагийн ерөнхий газар нь 2012 онд арилжааны банк болох Улаанбаатар банк дахь гэрээт албаны 2611008220, 2611157874 дансдаар гэрээт албаны орлого болон амралтын газрын, лавлагааны, банкны хүүгийн, журмын хашааны орлого болон хандив, тусламжийн, мөн төсвийн харилцах данснаас шилжүүлсэн тухайн тайлант оны төсвийн хэмнэлт зэрэг бусад орлогуудыг төвлөрүүлэн зарцуулжээ.

Уг дансдаар 2012 онд Цагдаагийн ерөнхий газрын гэрээт албаны гэх 8.0 тэрбум төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн боловч төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгээгүй байна. Уг дансыг 2003 оноос ашиглаж байгаа боловч 2012 оныг хүртэл төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэлгүй төрийн сангийн хяналтаас гадуур ашиглаж байжээ.

Энэ нь Төсвийн тухай тухай хуулийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэсэн заалтыг үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Дээр дурдсан 5,3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч биелэлтийг 2013 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга Б.Билэгт, ерөнхий нягтлан бодогч Ш.Эрхэмбаяр нарт даалгав.

АУДИТОР  Ш.ИЧИНХОРЛОО



070106